



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2013 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 1/92

Улаанбаатар хот

Нийслэлийн Авто замын газрын дүрэм, бүтэц, орон тоог батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Засгийн газрын 2012 оны 190 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Авто замын газрын дүрмийг нэгдүгээр, бүтэц, орон тоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Захирамжаар батлагдсан газрын дүрэмд нийцүүлэн байгууллагын дотоод журмыг боловсруулан батлах, орон тооны хязгаарт багтаан албан хаагчдыг томилох, нийт албан тушаалын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэх, цалин нэмэгдлийг зохих журмын дагуу тогтоон ажиллахыг Авто замын газар /Д.Нанзаддорж/-т үүрэг болгосугай.

3.Байгууллагын бүтэц, орон тоо өөрчлөгдсөнтэй холбогдуулан ажиллагсдын цалин хөлс, ажиллах нөхцлийг хангахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг Нийслэлийн 2013 оны төсвийн тодотголоор батлуулахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс/Э.Ганхүү/-т даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /Ё.Гэрэлчулуун/-т үүрэг болгосугай.

5.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2009 оны 108, 2011 оны 638 дугаар захирамжийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ




Э.БАТ-ҮҮЛ

D:\2013 zahiramj\дүрэм 2.docx

111020000481

Нийслэлийн Засаг даргын 2013 оны
 02 дугаар сарын 05-ны өдрийн
 А/92 дугаар захирамжийн хоёрдугаар
 хавсралт



НИЙСЛЭЛИЙН АВТО ЗАМЫН ГАЗРЫН
 БҮТЭЦ, ОРОН ТОО

№	Газрын нэр	Хэлтэс, нэгжийн нэр	Орон тооны хязгаар
1	Нийслэлийн Авто замын газар	Тамгын хэлтэс Төлөвлөлт судалгааны хэлтэс Газар чөлөөлөлт, инженерийн байгууламжийн хэлтэс Дотоод хяналт, дүн шинжилгээний хэлтэс Засвар ашиглалтын хяналтын хэлтэс Зам барилгын хяналтын хэлтэс	80 хүртэл үүнээс: дарга, орлогч-2
		Материал шинжилгээ, туршилт судалгааны лаборатори	17
		Шалган бүртгэх товчоо	29
	Нийт		126